

**“ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН 2017 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2018.03.30

Тус компани нь 2017 онд 135 хүний бүрэлдэхүүнтэйгээр Эрчим хүчиний зохицуулах Хорооноос авсан дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явууллаа.

Тус компаниас худалдан борлуулах дулааны эрчим хүчиний үнэ тарифыг Эрчим хүчиний зохицуулах Хорооны 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 53 дугаар тогтоолоор шинэчлэн тогтоолгож мөрдөж ажиллаж байна.

Тус бүр нь 13 Гкал/цаг-ийн хүчин чадалтай KE25-14 маркийн 3 зуух, 20 Гкал/цаг-ийн хүчин чадалтай KBKC-20-150 маркийн 1 зуухтайгаас KE25-14 маркийн 1 зуухыг нөөцөд байлгаж үлдсэн 3 зуухыг ажиллагаанд оруулж ажилласан.

Нийт 859 хэрэглэгчтэйгээс айл өрх 796, төсөвт байгууллага 37, үйлдвэр, аж ахуйн нэгж 90 байна.

Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагаанаас 3,099,135,4 төгрөгийн орлого олж 3,080,481,4 төгрөгийн зарлага гаргаж 18,654,000 төгрөгийн ашигтай ажилласан.

2017 онд мөнгөн хөрөнгө 31,166,8, дансны авлага 482,593,100, татвар, бусад авлага 66,907,2, бараа материал 498,066,8, эргэлтийн хөрөнгийн нийт дүн 1.078,733,9 төгрөг болсон байна.

Үндсэн хөрөнгө 1.438.065,5, биет бус хөрөнгө 119.704.80, эргэлтийн бус хөрөнгийн дүн 1.557,770,3, нийт хөрөнгийн дүн 2.636,504,2 төгрөг байна.

Дансны өглөг 115,188,8, татварын өглөг 20,100,3, нийгмийн даатгалын 70,9, богино хугацаат зээл 1.534,748,0 , нийт өр төлбөрийн дүн 1.670.108,0 төгрөг болсон байна.

Мөнгөн зарлагын дүн 3,080,484,4 төгрөг байгаагаас ажиллагсадад олгосон мөнгө 523,042,3, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө 66,727,6, бараа, материал худалдан авахад төлсөн мөнгө 38,574,3, ашиглалтын зардалд төлсөн

мөнгө 1,305,544, түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгслийн үнэд 912,195,8, хүүд төлсөн 224,325,4, татварын байгууллагад төлсөн 10,065 төгрөг байна.

Компанийн 2017 оны санхүүгийн тайланг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон гаргаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитыг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “Акпар аудит” ХХК-иар хийлгэсэн болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЕРӨНХИЙ НЯ-БО



М.ТИЛЕУБЕРДИ

Т.БИРЛЕСХАН